



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

Г “Ган зам даатгал” ХХК-д дүрмийн сангийн 7
хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ган зам даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг нийт 500 000 000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1 000 000 000.0 /нэг тэрбум/ төгрөгт хүргэж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчийн нэр	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “УБТЗ”	500 000 000.0	500 000 000.0	1 000 000 000.0	100,0%
	Нийт	500 000 000.0	500 000 000.0	1 000 000 000.0	100,0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2011 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ган зам даатгал” ХХК/Д.Махвал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН